

**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГЫН ҮҮРЭГТ АЖЛААС
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2020 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны дарга Аюушийн Ариунзаяа нь Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан тушаалд нэр дэвшиж байгаатай холбогдуулан үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх өргөдлөө 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хурлын даргад гаргасныг Эдийн засгийн байнгын хорооны 2020 оны 07 дугаар сарын 09-ний хуралдаанаар хэлэлцлээ.

А.Ариунзаяаг Үндэсний статистикийн хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын даргын саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.


Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 13¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоолын төслийг боловсруулж, өргөдлийн хамт Та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

А.Ариунзаяаг Үндэсний статистикийн хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



Б.БАТТӨМӨР


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА ӨРГӨДӨЛ ГАРГАХ НЬ:

2020 оны 7 дугаар сарын 08-ны өдөр

Үндэсний статистикийн хорооны дарга А.Ариунзаяа миний бие 2016 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 21 дүгээр тогтоолоор Үндэсний статистикийн хорооны даргаар томилогдож Статистикийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн удирдан зохион байгуулах, Үндэсний статистикийн хорооны бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Үндэсний статистикийн хорооны зөвлөл, Үндэсний статистикийн хорооны арга зүйн байнгын зөвлөл, Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлийг удирдах, Олон улсын Статистикийн байгууллагын гишүүний эрх үүргийг хэрэгжүүлэх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг Статистикийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүрэг, бүрэн эрхээ амжилттай хэрэгжүүлэн 4 дэх жилдээ ажиллаж байна.

А.Ариунзаяа миний бие Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр шинээр байгуулагдаж байгаа Монгол Улсын Засгийн газарт Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан тушаалд нэр дэвшиж байгаа тул Үндэсний статистикийн хорооны даргын үүрэгт ажлаас Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 13¹ дүгээр зүйлийн 13^{1.4} дэх хэсгийн 3 дугаар заалтад заасны дагуу чөлөөлж өгнө үү.

ӨРГӨДӨЛ ГАРГАСАН:



А.АРИУНЗАЯА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

Үндэсний статистикийн хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 13¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өөрийнх нь хүсэлтийг харгалзан Аюушийн Ариунзаяаг Үндэсний статистикийн хорооны даргын үүрэгт ажлаас 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

5 дугаар зүйл. Улсын Их Хурлын шийдвэр

5.1. Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах бөгөөд Улсын Их Хурлын бусад шийдвэр тогтоолын хэлбэртэй байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ
ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

108 дугаар зүйл. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэх журам

108.1. Хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх санал гаргасан бол холбогдох Байнгын хороо 7 хоногийн дотор хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

108.2. Нэгдсэн хуралдаан эрх бүхий албан тушаалтны санал, холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.

108.3. Томилогдох нэр дэвшигч хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэг авч чадаагүй бол эрх бүхий албан тушаалтан өөр хүнийг нэр дэвшүүлэхээр санал болгох бөгөөд чөлөөлөх саналыг дэмжээгүй бол уг саналыг дахин оруулж болно.

108.4. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

СТАТИСТИКИЙН ТУХАЙ

13¹ дүгээр зүйл. Үндэсний статистикийн хорооны удирдлага

13¹.4. Үндэсний статистикийн хорооны даргын бүрэн эрх дараахь тохиолдолд дуусгавар болно:

1/хуульд заасан бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

2/эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй болсон;

3/албан тушаалаас чөлөөлж өгөхийг өөрөө хүссэн;

4/үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн;

5/гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шийдвэр нь хүчин төгөлдөр болсон.